

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 7 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Батцогт**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж нарын 6 гишүүний 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2013 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хэлэлцэн Төрийн байгуулалтын байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2013 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Батцогт нар “улсын баяр наадамд түрүүлсэн арслан цолтой бөхөд хуулийн төсөлд заасан болзлыг хангасан тохиолдолд аварга цол олгох,” Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт “тэгш ой тохиосон улсын баяр наадамд үзүүрлэсэн бөхөд улсын арслан цол олгох”, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж “энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө уг хуульд заасан болзлыг хангасан бөхөд харгалзах цолыг олгох” талаар тус тус санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

